



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 7/13

Улаанбаатар хот

Үйлчлүүлэгчийн унаж бэртэх
эрсдэлээс сэргийлэх журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр батлах тухай” 225 дугаар тогтоолын 6 дугаар зорилт, 2018 оны “Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 163 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар зорилт, Монгол Улсын стандарт MNS:6211-2019, Үйлчлүүлэгчийн унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн засах төвийн орчинд үйлчлүүлэгчийн унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлэн ажиллахыг нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Сэргээн засах төвийн орчинд үйлчлүүлэгчийн унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааны санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг нягтлан бодогч /Ц.Тунгалаг/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын багийн ахлагч /Н.Дарьсүрэн/, Захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч /Ц.Уранчимэг/ нарт даалгасугай.

ДАРГА Ш.Саруултуяа Ш.САРУУЛТУЯА



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 03 сарын 02 өдрийн
А/13 дугаар тушаалын 1 хавсралт



**ЭМНЭЛГИЙН ОРЧИНД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН УНАЖ БЭРТЭХ
ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Сэргээн засах төвөөр үйлчлүүлэх явцад унаж бэртэх эрсдэлийн түвшинг тогтоох, эрсдэл бүхий үйлчлүүлэгчийг онцгой анхаарч, унах эрсдэлийг бууруулах, уналтаас үүсэх бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Сэргээн засах төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч, ажилтнууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3. Унаж бэртэх гэдэг нь ихэвчлэн шал, шат, газар зэрэг гулсамтгай гадаргуу дээр дийлэнх тохиолдолд гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр халтирч унах үйл явдал бөгөөд гэнэт, хяналтгүй, санаандгүй босоо байдлаа алдах, эсвэл эд зүйлсэд тээглэж бүдрэх, тодорхой нэг түвшнээс өөр түвшинд шилжих явцад хий гишгэх, ямар нэгэн зүйл мөргөх буюу газар унахыг хэлнэ. Энэ ойлголтод ухаан алдаж унах, муужирах эсвэл эпилепси өвчний улмаас татаж унах уналт хамаарахгүй.

ХОЁР. ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ

- 2.1. Дотоод хүчин зүйлс
 - Алхааны өөрчлөлт
 - Яс, үе мөчний үрэвсэл (доод мөчдийн булчингийн сулрал, тавхайн эмгэгүүд)
 - Хөдөлгөөний мэдрэлийн эмгэг (тархины саажилт)
 - Цус багадалт
 - Шингэний дутагдал
 - Хараа - сонсголын өөрчлөлт
 - Бодисын солилцооны өөрчлөлтүүд: бамбай булчирхайн эмгэг, амьсгал зүрх судасны өвчин, бусад цочмог өвчин
- 2.2. Гадаад хүчин зүйлс гэж гадаад орчноос хамааралтай биеийн байдалтай холбоогүй буюу орчны шаардлага хангаагүй байдал нөлөөлж болохыг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй нэгж бүр онцгой анхаарч дараах учирч болзошгүй эрсдэлүүдийг урьдчилан тооцоолж, орчны аюулгүй байдлыг хангаж ажиллавал зохино. Үүнд:

- Нийтийн талбайд хайрцаг, сав, хураасан зүйл хадгалахгүй байх. Сэргээн засах төвөөр үйлчлүүлэхээр ирсэн хэн нэгэн төдийгүй төвийн ажилтан санаандгүй хураасан эд зүйлд бүдэрч унах, гэмтэх тохиолдлоос ямагт сэргийлж байх хэрэгтэй. Нийтийн талбай хүн зорчиход чөлөөтэй, цэвэрхэн, оношилогоо, эмчилгээний өрөө болон бусад тасаг, нэгжийг заах чиглүүлэгчтэй байвал зохино. Түүнчлэн нийтийн талбайн шалны хулдаас урагдаж, сэртийсний улмаас түүгээр явж буй үйлчлүүлэгч, хүнд үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхээр яарсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн ч бүдэрч унах аюултай тул нэн даруй засаж байх
- Шатнаас унах. Шатны гишгүүр хэт өндөр, ирмэг нь эмтэрхий, тавцан нарийн алхмын зөрүүтэй, шатны бариул зэрэг аюулгүй байдлыг хангах нэмэлт тоноглол, хэрэгслээр хангах
- Халтирч унах. Шал нойтон үед халтирах аюултай бөгөөд бие засах өрөөний шал гол төлөв халтирч болзошгүй плитан шалтай байдаг нь хөл муу, таягтай, албадмал байрлалд байгаа, эмийн эмчилгээний гаж нөлөө илэрсэн үйлчлүүлэгчийн хувьд аюултай орчин тул анхаарах
- Толгой эргэж унах. Ямар ч шалтгааны улмаас (артерийн даралт ихсэх ба багадаа, цус багадаа, хагалгааны дараа, эмийн эмчилгээний гаж нөлөө гэх мэт) толгой эргэж унаж болзошгүй тул сэргээн засах төвийн хана түшиж явах бариултай байх
- Хаалганы босгонд тээглэж унах. Өрөө тасалгаанууд босготой байх нь үйлчлүүлэгчдийн бүдэрч, тээглэж унах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн яаралтай тусламжийн үед зөөврийн ор хэрэглэх, суугаа хүний тэргэнцрээр тээвэрлэхэд бэрхшээлтэй байдаг тул анхаарах;

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ

3.1. Асуумжийн арга

- 3.1.1 Үзлэг хийж буй эмч үйлчлүүлэгчээс сүүлийн нэг жилийн дотор унаж бэртсэн эсэхийг тодруулна. (Хэрэв унаж байсан өгүүлэмжтэй бол давтамж, унасан орчин нөхцөлийг асууж, явахад хүндрэл саадтай эсэх, тэнцвэр алддаг эсэх, унах айдас байдаг эсэхийг асууна)
- 3.1.1 Хэрэв тухайн үйлчлүүлэгч унаж гэмтсэн учир эмчид хандаж байгаа буюу сүүлийн нэг жилд уналт давтагдсан эсэх, алхах гишгэхэд хүндрэлтэй, тэнцвэр алддаг бол унаж бэртэх эрсдэлтэй гэж үнэлээд дараах асуумжийг авна.

- 3.1.2 Унаж бэртсэн орчин нөхцөл, нөлөөлсөн эрсдэлт хүчин зүйл, уналтын давтамж, илэрсэн шинж тэмдэг, гэмтэл бэртэл, бусад үр дагавар
- 3.1.3 Эмийн хэрэглээ (эмийн тоо ба тун хэмжээ, хэрхэн хэрэглэдэг зэргийг асуух)
- 3.1.4 Унахад нөлөөлөх дотоод эрсдэлт хүчин зүйлс (цочмог ба архаг өвчин байгаа эсэх)
- 3.2 Биеийн үзлэг
- 3.2.1 Үйлчлүүлэгчийг хариуцсан эмч тэдний алхаа, тэнцвэрийн байдал ба хөлийн үений хөдөлгөөний далайц болон үйл ажиллагааны чадварыг үнэлэх шаардлагатай.
- 3.2.2 Мэдрэлийн тогтолцооны талаас танин мэдэхүйн чадвар ба хөлийн булчингийн хүчийг үнэлэх, өнгөц болон гүний мэдрэхүйн алдагдал, бага тархины үйл ажиллагааны сорил, шөрмөсний рефлексийг шалгана.
- 3.2.3 Зүрх судасны тогтолцооны талаас зүрхний хэм агшилтын тоо, судасны цохилт, артерийн даралт хэмжих, хөлийн цусан хангамжийг шалгах хэрэгтэй.
- 3.2.4 Харааны үйл ажиллагааг үнэлнэ.
- 3.2.5 Хөлийн тавхайг шалгана. (арьсны байдал, холголт, яс, эвэр ургасан эсэх)
- 3.3 Өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ
- 3.3.1 Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ сувилагч бүр үйлчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа гүйцэтгэх чадварын үнэлгээ хийх хэрэгтэй.
- 3.3.2 Шаардлагатай бол явахад дэмжлэг болох нэмэлт хэрэгслүүдийг үйлчлүүлэгч зөв хэрэглэж байгаа эсэхийг үнэлвэл зохино.
- ДӨРӨВ. УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**
- 4.1 Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж буй сувилагч бүх үйлчлүүлэгчид унаж бэртэх эрсдэл байгаа эсэхийг дараах үнэлгээгээр тодорхойлно. Эмнэлгийн ажилтан бүр унаж бэртэх эрсдэлтэй үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ анхаарч ажиллахаас гадна үйлчлүүлэгч болон тэдний ар гэрийнхэнд унаж бэртэхээс сэргийлэх тухай заавар зөвлөгөөгөөр хангана.
- 4.1.1. 0-16 хүртэл насныхан буюу хүүхэд болон нярайн үнэлгээ нь хүүхдийн насны үечлэлээс хамааран харилцан адилгүй байхаас гадна онош, эмийн хэрэглээ зэрэг нийт долоон үзүүлэлтээс бүрдэнэ. (Хүснэгт 1)

Хүүхэд болон нярайн үнэлгээ

Үйлчлүүлэгчийн овог, нэр: Нас, хүйс:

Үзүүлэлт	Шалгуур	Оноо
Нас	3 хүртэлх нас	€ 4
	3-7 нас хүртэлх	€ 3
	7-13 нас хүртэлх	€ 2
	13 ба түүнээс дээш	€ 1
Хүйс	Эрэгтэй	€ 2
	Эмэгтэй	€ 1
Онош	Мэдрэлийн онош	€ 4
	Хүчилтөрөгчийн өөрчлөлт (амьсгалын замын онош, шингэний дутагдал, цус багадалт, хоолны дуршил буурах, ухаан балартах, толгой эргэх)	€ 3
	Сэтгэц/ зан төрхийн эмгэг	€ 2
	Бусад онош	€ 1
Танин мэдэхүйн өөрчлөлт	Танин мэдэхүй хязгаарлагдмал	€ 3
	Мартамхай	€ 2
	Хэвийн	€ 1
Орчны хүчин зүйлс	Унаж бэртэж байсан эсвэл нярайн ор, хүүхдийн тэрэг зэргийг ашиглаж байгаа	€ 4
	Нярайн туслах хэрэгсэл хэрэглэдэг эсэх (Хөлд оруулагч)	€ 3
	Үйлчлүүлэгч орон дээр байгаа	€ 2
	Амбулаторийн хэсэг	€ 1
Мэс ажилбар /тайвшруулалт	24 цагийн дотор	€ 3
	48 цагийн дотор	€ 2
	48 цагаас дээш/ үгүй	€ 1
Эмийн хэрэглээ	Тайвшруулах эм (сэтгэц нөлөөт эм, шээс хөөх ба туулгах эм, нойрсуулах эм, сэтгэл хөөрлийн эсрэг эм, сэтгэл гутралын эсрэг эм, таталтын эсрэг эм)	€ 3
	Дээрх эмүүдийн нэгийг хэрэглэж байгаа	€ 2
	Бусад эм/ үгүй	€ 1
Нийт оноо		

Сувилагчийн нэр:

Огноо, Цаг:

Ахлах сувилагчийн нэр:

Огноо, Цаг:

ТАВ. УНАЖ БЭРТЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1 Сэргээн засах төвийн орчин нь аюулгүй бөгөөд унах эрсдэлийг бууруулах тохижилттой байх нь амбулаторийн орчинд унах эрсдэлийг бууруулах үндэс юм. Сэргээн засах төв үйлчлүүлэгчийг унах эрсдэлд хүргэж болзошгүй байршлуудыг тодорхойлон үйлчлүүлэгчдэд унахаас сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.1.1. Сэргээн засах төвөөр үйлчлүүлж байгаа иргэд нь бүгд унах өндөр эрсдэлтэй тул байнгын хараа хяналтанд байлгаж гараас гарт хүлээлгэн өгөх
 - 5.1.2. Өрөөний шал хуурай, шалан дээр хөлд тээглэх зүйл байгаа эсэхийг анхаарч, шал нойтон болон тээглэх саадтай зүйл байвал шалыг арчуулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах зэргээр зохих арга хэмжээг даруй авна.
 - 5.1.3. Шат налуу газруудад хашлага, бариул хийх, гулсахаас сэргийлсэн аюулгүй тэмдэглэл байршаалах
 - 5.1.4. Үзлэг шинжилгээний ширээн дээр хүүхдийг хараа хяналтгүй үлдээхгүй байх
 - 5.1.5. Хэрэв шаардлагатай бол хөдөлгөөн хязгаарлагчийг холбогдох журмын дагуу ашиглана.
 - 5.1.6. Унаж бэртэх эрсдэлтэй үйлчлүүлэгчийг асран хамгаалагчийн хамт сургалтад хамруулах ба үйлчлүүлэгчийг асран хамгаалагчгүйгээр орхиж явахгүй байх талаар сургалтад тодорхой заана.
 - 5.1.7. Үйлчлүүлэгчид хөлд тохирсон халтирдаггүй ултай гутал өмсгөж, нүдний шил цэвэр байх нь харах болон явах чадварт сайнаар нөлөөлдөг учир анхаарах хэрэгтэй.
 - 5.1.8. Бие засах өрөөнд түших, дэмжлэг авах бариул байрлуулах, гэрэлтүүлэг хангалттай эсэхийг шалгавал зохино.
 - 5.1.9. Хүүхдийн биеийн жинг үзэхдээ сувилагч нэг гараа хүүхдэд ойр байлгах хэрэгтэй.
 - 5.1.10. Сэргээн засах төвийн гадна үйлчлүүлэгч халтирч унахаас сэргийлж өвлийн улиралд цасаа байнга цэвэрлэж байх
 - 5.1.11. Төвийн гадна хаалганы шат хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ороход зориулсан налуу зам бариулыг байнга засаж байх
 - 5.1.12. Эмчилгээний хэсгийн асрагч нар 00 өрөөнд хүүхэд хараа хяналтгүй орхихгүй, асгарч цацагдсан усыг тэр даруйд нь арчих, шалавчийг байнга

хуурай байлгах

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨӨВӨРЛӨХ ҮЕД УНАЖ БЭРТЭХЭЭС СЭРГИЙЛЭХ

- 6.1. Өглөө бүр хүүхдүүдээ эцэг эх, асран хамгаалагч нь сувилагч нар хүлээлгэж өгнө.
- 6.2. Сэргээн засах төвийн шатаар хүүхэд унаж сэргийлж хаалт хийх
- 6.3. Сэргээн засах төвийн гадна үүдэнд хүүхэд хальтарч унахаас сэргийлж шатны зөөлөвч наалт тогтоож байх
- 6.4. 1 байрны хүүхдийг өглөөний, өдрийн, нэмэгдэл хоол тарганд ороход сувилагч, асрагч нарт гараас гарт хүлээлгэн өгнө.

ДОЛОО. АМБУЛАТОРИД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ УНАЖ БЭРТЭХЭЭС СЭРГИЙЛЭХ

7.1 Амбулаторид үйлчлүүлэгч унаж бэртэх эрсдэлтэй байдаг тул дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй. Үүнд:

- 7.1.1. Шалан дээр халтирч болох эд зүйлс эсвэл шал нойтон байвал арчих, саадыг арилгасан байх;
- 7.1.2. Үйлчлүүлэгчийг эмчилгээний орноос буухад анхаарч туслах;
- 7.1.3. Тэргэнцэртэй болон хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг анхаарч туслах;
- 7.1.4. Хэрэв үйлчлүүлэгч хагас саажилттай бол хөдлөхөд нь дэмжлэг үзүүлэх;

НАЙМ. УНАХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

- 8.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэнд нийгмийн ажилтанууд үйлчлүүлэгч болон тэдний ар гэрийнхэнд унах эрсдэлээс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгож болно.
- 8.2. Эрүүл мэндийн боловсрол олгосны дараа сургалтын агуулга, унах эрсдэлийн түвшин, үнэлгээний оноо, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн боловсролын талаарх ойлголтыг нэгтгэн өвчний түүхэнд амбулаторийн картанд тэмдэглэл хөтөлнө.

ЕС. УНАЖ БЭРТСЭН ҮЕД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 9.1. Унасны дараа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхээс өмнө хөдөлгөхгүй байх, хэрэв ямар нэгэн ноцтой гэмтэл, бэртэлтэй авсан бол зөөвөрлөхөд тохиромжтой тэргэнцэр эсвэл дамнуургаар зөөвөрлөх хэрэгтэй.

- 9.2. Ухамсарт ухаан, амин үзүүлэлт болон өвдөлтийн үнэлгээ хийнэ.
- 9.3. Удирдах албаны хүмүүс болон эмчид мэдээлнэ.
- 9.4. Үйлчлүүлэгч, тэдний асран хамгаалагчид унаж бэртэхээс сэргийлэх эрүүл мэндийн боловсролыг давтан олгож, холбогдох гарын авлага, сургалтын материалыг олгоно.
- 9.5. Унасны дараа тохиолдол мэдээллэх хуудсаар тухайн үйлчлүүлэгчийн ерөнхий мэдээлэл болон унасан шалтгаан, бэртэл гэмтлийн зэрэг, нөлөөлсөн хүчин зүйл зэргийг мэдээлнэ.
- 9.6. Унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх боломж байгаа эсэхийг илрүүлж, сайжруулах чиглэлийг тодорхойлохын тулд дотоод хяналтыг байнга хийнэ.